



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

2019 оны 4 дүгээр сар


Ерөнхий тойм: Энэ оны эхний 4 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 15%-иар буюу 571 сая ам.доллараар өсч 4,278 сая ам.доллар байв. Үүнд экспорт 18%-иар буюу 387 сая ам.доллараар, импорт 12%-иар буюу 184 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 202 сая ам.доллараар өсч 746 сая ам.долларын ашигтай байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 4 сар			Өөрчлөлт			
	2016	2017	2018	2017/2016		2018/2017		2017	2018	2019	2018/2017		2019/2018	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	8,274	10,536	12,887	2,262	27%	2,351	22%	3,017	3,707	4,278	690	23%	571	15%
Экспорт	4,916	6,201	7,012	1,284	26%	811	13%	1,900	2,125	2,512	226	12%	387	18%
Импорт	3,358	4,335	5,875	977	29%	1,540	36%	1,118	1,582	1,766	464	42%	184	12%
Тэнцэл	1,558	1,865	1,137	307		(728)	-39%	782	543	746	(238)	-31%	202	37%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** 2019 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 191 сая ам.доллараар өсч 801 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 65% буюу 2,769 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 12% буюу 512 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 1.8%-иар буурсан бол БНХАУ-тай хийсэн худалдаа 15%-иар өслөө.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2019 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 14%-иар өссөн хэдий ч өмнөх сараас 2%-иар буурч 2.174-д хүрлээ. Худалдааны нөхцөл өмнөх сараас муудахад хөрөнгө оруулалтын болон нефтийн барааны импортын үнийн өсөлт голлон нөлөөлөв.

*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

Экспорт 2019 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 18%-иар буюу 387 сая ам.доллараар өсөв. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь нийт экспортыг 17 нэгж хувиар өсгөх чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.2 нэгж хувиар, мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 0.3 нэгж хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 2. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2017			2018			2019			Δ (2018/2017)			Δ (2019/2018)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²	Дүн	Өсөлт	%²
1. Уул уурхай		1,707	90%	1,944	91%	2,301	92%	237	14%	12%	357	18%	17%		
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	502	524	28%	459	628	30%	489	701	28%	104	20%	5%	74	12%	3%
1.2. Чулуун нүүрс	11432	766	40%	10,142	790	37%	11,385	961	38%	23	3%	№	171	22%	8%
1.3. Боловсруулаагүй нефть	2,430	123	6%	2,210	139	7%	2,106	118	5%	16	13%	№	(20)	-15%	-1%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	1,742	114	6%	2,036	93	4%	2,842	159	6%	(21)	-19%	-1%	67	72%	3%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	1,889	76	4%	3,432	144	7%	4,665	196	8%	69	91%	4%	51	36%	2%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	38	57	3%	42	75	4%	54	79	3%	18	31%	№	4	5%	0%
1.7. Жонош, лейцит, нефелинт	79	18	1%	114	36	2%	152	55	2%	18	98%	№	19	51%	№
1.8. Молибдений хүдэр, баяжмал	2	11	1%	2	14	1%	2	16	1%	3	31%	0%	2	13%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	1	0%	0	1	0%	0	1	0%	0	10%	0%	(0)	0%	0%
1.10. Мөнгө /тонн/	0	0	0%	0	0	0%	0	-	0%	(0)	0%	0%	(0)	0%	0%
1.11. Бусад	152	17	1%	187	23	1%	75	15	1%	6	36%	0%	(9)	-37%	0%
2. Мал аж, ахуй	154	91	5%	161	97	5%	147	122	5%	6	7%	0%	25	26%	1%
2.1. Амьд мал, малын мах	3	6	0%	7	16	1%	9	17	1%	10	165%	№	1	9%	0%
2.2. Арьс, шир	145	13	1%	147	8	0%	129	6	0%	(4)	-35%	0%	(2)	-24%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	1	0%	0	3	0%	0	3	0%	1	94%	0%	0	0%	0%
2.4. Ноолуур	2	66	3%	4	66	3%	3	87	3%	(0)	0%	0%	21	32%	1%
2.5. Ноос, бусад үс, хялгас	3	4	0%	2	4	0%	4	8	0%	(1)	-14%	0%	5	124%	0%
2.6. Бусад	1	1	0%	0	1	0%	1	1	0%	(0)	-4%	0%	0	2%	0%
3. Газар тариалан	35	3	0%	2	1	0%	15	3	0%	(2)	-66%	0%	2	256%	0%
4. Аж үйлдвэрлэл	160	99	5%	81	83	4%	152	85	3%	(15)	-15%	-1%	1	2%	0%
4.1. Хүнс	9	38	2%	8	25	1%	10	24	1%	(13)	-35%	-1%	(1)	-3%	0%
4.2. Ноолууран адал	0	4	0%	0	5	0%	0	9	0%	1	29%	0%	4	74%	0%
4.3. Бусад хувцас, пүтэл, адал	0	3	0%	1	4	0%	1	3	0%	0	12%	0%	(0)	-9%	0%
4.4. Уул уурхай	11	35	2%	13	36	2%	45	35	1%	2	4%	0%	(1)	-3%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	25%	0%	0	9%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	17	1%	1	11	1%	0	10	0%	(5)	-32%	0%	(1)	-8%	0%
4.7. Бусад	139	2	0%	58	2	0%	96	2	0%	0	1%	0%	0	25%	0%
5. Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	8%	0%	(0)	-7%	0%
Нийт дүн	1,900	1,900		2,125	2,125		2,512	2,512		226	12%		387	18%	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 3. Экспортын өөрчлөлт, 2019 оны эхний 4 сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Үнийн	%	Нийт	%
1. Уул уурхай	250		108		357	18%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	44	59%	30	41%	74	12%
1.2. Чулуун нүүрс	105	61%	66	39%	171	22%
1.3. Боловсруулаагүй нефть	(6)	29%	(14)	71%	(20)	-15%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	45	21	67	72%	67	72%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	52	101%	(0)	-1%	51	36%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	18	513%	(15)	-413%	4	5%
1.7. Жонош, лейцит, нефелинт	14	74%	5	26%	19	51%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	(0)	-5%	2	105%	2	13%
1.11. Бусад	(22)	256%	13	-156%	(9)	-37%
2. Мал аж, ахуй	(9)		34		25	26%
2.1. Амьд мал, малын мах	3	250%	(2)	-150%	1	9%
2.2. Арьс, шир	(1)	44%	(1)	56%	(2)	-24%
2.3. Малын өлөн гэдэс	0	10%	0	90%	0	0%
2.4. Ноолуур	(16)	-78%	37	178%	21	32%
3. Газар тариалан	3		(1)		2	256%
4. Аж үйлдвэрлэл	13		(12)		1	2%
5. Бусад	0		(0)		(0)	-7%
Нийт дүн	257		130		387	18%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

2019 оны эхний 4 сард экспортын гадаад худалдааны тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 257 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 130 сая ам.доллараар тус тус өслөө. Чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 149 сая ам.доллараар, үнийн өсөлтөөс шалтгаалж 96 сая ам.доллараар өсөв. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өссөнөөс шалтгаалж 13 сая ам.доллараар өссөн боловч үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 12 сая ам.доллараар буурсан байна.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2019 оны 4 дүгээр сард 1,286 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 3.7%-иар, өмнөх сараас 1.2%-иар буурсан байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,438; 94 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 6%-иар буурсан бол төмрийн хүдэр 42.5%-иар өссөн, өнгөрсөн сараас зэсийн үнэ бага зэргийн буурсан бол төмрийн хүдэр 7.4%-иар өссөн. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 4 дүгээр сард 87 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 10%-иар, өмнөх сараас 4.8%-иар өслөө.

Импорт 2019 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 12%-иар буюу 184 сая ам.доллараар өсөв. Импортын 12 нэгж хувийн өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 7 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүн болон нефтийн бүтээгдэхүүний өсөлт тус бүр 3 нэгж хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 4. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2017			2018			2019			Δ (2018/2017)			Δ (2019/2018)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%?	Дүн	Өсөлт	%?
Хэрэглээний бүтээгдэхүүн		365	33%		445	28%		498	28%	79	22%	7%	54	12%	3%
Түргэн эдэлгээтэй	264	201	18%	283	243	15%	267	249	14%	42	21%	4%	6	2%	0%
Хүнс	101	137	12%	132	169	11%	124	176	10%	32	23%	3%	7	4%	0%
Эм, тариа	1	28	3%	1	32	2%	1	30	2%	4	15%	0%	(2)	-7%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	162	36	3%	150	42	3%	142	43	2%	6	16%	1%	1	2%	0%
Удаан эдэлгээтэй	62	164	15%	54	202	13%	120	249	14%	38	23%	3%	48	24%	3%
Гутал, хувцас, цүнх	20	18	2%	16	22	1%	22	20	1%	4	23%	0%	(2)	-8%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	25	26	2%	17	33	2%	76	32	2%	7	25%	1%	(1)	-4%	0%
Авто машин, түүний салбэр хэрэгсэл	0	102	9%	0	124	8%	1	171	10%	22	22%	2%	46	37%	3%
Бусад удаан эдэлгээтэй бараа	17	18	2%	21	22	1%	21	27	2%	5	26%	0%	5	22%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	322	387	35%	525	601	38%	412	717	41%	214	55%	19%	116	19%	7%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	7	268	24%	7	394	25%	9	501	28%	126	47%	11%	107	27%	7%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	0	50	5%	0	115	7%	1	169	10%	65	129%	6%	53	46%	3%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	7	217	19%	6	278	18%	8	333	19%	61	28%	5%	54	19%	3%
Барилгын материал	105	74	7%	156	140	9%	224	163	9%	65	88%	6%	23	17%	1%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	13	45	4%	12	68	4%	7	53	3%	23	51%	2%	(14)	-21%	-1%
Аж үйлдвэрлэлийн орц	363	149	13%	447	236	15%	563	201	11%	87	58%	8%	(35)	-15%	-2%
Хүнсний орц	13	6	1%	187	52	3%	12	6	0%	46	763%	4%	(46)	-88%	-3%
Химийн бүтээгдэхүүн	47	27	2%	59	34	2%	66	35	2%	7	26%	1%	1	3%	0%
Даавуу, утас, арьс, савжин эдлэл	11	7	1%	18	8	0%	25	10	1%	1	17%	0%	2	24%	0%
Цахилгаан эрчим хүч	0	43	4%	1	47	3%	1	46	3%	4	10%	0%	(1)	-2%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	1	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-23%	0%	0	98%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	249	66	6%	261	95	6%	308	103	6%	29	44%	3%	9	9%	1%
Нефтийн бүтээгдэхүүн	363	214	19%	447	297	19%	563	347	20%	83	39%	7%	50	17%	3%
Дизель түлш	199	108	10%	256	165	10%	334	207	12%	57	53%	5%	43	26%	3%
АИ-92, АИ-95	114	69	6%	99	67	4%	161	91	5%	(2)	-3%	0%	24	35%	1%
А-80 болон бусад	50	37	3%	91	65	4%	67	49	3%	28	77%	3%	(16)	-24%	-1%
Бусад	6	2	0%	9	3	0%	43	2	0%	1	27%	0%	(1)	-36%	0%
Нийт дүн		1,118		1,582		1,766		464	42%		184	12%			

%? - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 5. Импортын өөрчлөлт, 2019 он эхний 4 сар

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Үнийн	%	Нийт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	54	100%	(0)	0%	54	12%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	190	163%	(74)	-6.3%	116	19%
Аж үйлдвэрлэлийн орц	(66)		31		(35)	-15%
Нефтийн бүтээгдэхүүн	66	130%	(15)	-3.0%	50	17%
Дизель түлш	48	113%	(6)	-1.3%	43	26%
АИ-92, АИ-95	35	148%	(11)	-4.8%	24	35%
А-80 болон бусад	(17)	110%	2	-1.0%	(16)	-24%
Бусад	2		(3)		(1)	-3.6%
Нийт дүн	245	133%	(61)	-3.3%	184	12%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2019 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 116 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 54 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 50 сая ам.доллараар тус тус өссөн бол аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүний импорт 2 сая ам.доллараар буурснаар нийт импорт 184 сая ам.доллараар өслөө.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2019 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 1 хувиар, өмнөх сараас 5 хувиар өсч тонн тутамд 648 ам.долларт хүрэв.